

НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ШҮҮМЖ

М. Сладковский ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч
гишүүн **К. Шевелев**. Түүхийн ухааны дэд эрдэмтэн

**ХЯТАДЫН КОММУНИСТ НАМЫН VI ИХ ХУРЛЫН
50 ЖИЛИЙН ОЙ* (Орчуулга)**

1928 оны зургадугаар сарын 18-наас долоодугаар сарын 11-нийг дуустал хуралдсан ХКН-ын VI их хурал хятадын коммунист ба хувьсгалт хөдөлгөөний түүхэнд том үйл явдал болсон юм. Их хурлаас гаргасан шийдвэр олон жилийн турш Хятадын ард түмний үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө тэмцэлд удирдлага нь болж байжээ.

Их хурал 1925—1927 оны үндэсний хувьсгал дарагдсаны дараахь, намд онцгой хүнд байсан үед хуралдсан билээ. Чан Кай-ши болон гоминьданы бусад зүтгэлтнүүд нэгдсэн фронтыг ХКН-аас таслангуутаа хөдөлмөрчин олон түмэн, түүний манлай Хятадын Коммунист Намыг зэрлэгээр нухчин дарж эхэллээ. Аллага хядлага ширүүсч байсан энэ үед ХКН хүнд хохирлыг хүлээсэн юм. Ажилчны хөдөлгөөн сулрах хандлагатай болж, олон тооны хувьсгалт үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд бут цохигдож, ХКН ба ажилчин анги хоёрын хэлхээ холбоо түр суларсан байлаа. Нөгөөтэйгүүр бослогонд хамрагдсан хөдөө орон нутгийн хэд хэдэн районд шинэ гишүүд намд бөөнөөр орж эхэлсэн боловч тэдний ихэнх нь улс төрийн талаар боловсроогүй, пролетарийн биш санаа бодолтой хүмүүс байв.

Намын стратеги, тактикийн үндсэн асуудлын талаар маргалдаж байсан ХКН-ын удирдлагыг ч гэсэн энэ хямрал хамарчээ.

Ийм ярвигтай хэцүү цагт ХКН-д Коммунист интернационал чухал тусламж үзүүлжээ. Коминтерний гүйцэтгэх Хорооны IX бүгд хурлаас тэмдэглэхдээ: «тухайн үед намын ажлын гол нь сая сая ажилчин тариачныг өөртөө татах, тэднийг улс төрийн боловсролтой болгох, тэдгээр нам ба түүний лоозонг хүрээлүүлэхэд чиглэнэ...» гэжээ.

Бүгд хурал ХКН-д хандаж төрийн хуйвалдаан хийх, бослогоор тоглох, зүүний үг яриагаар хөөцөлдөх зэргийн эсрэг шийдвэртэй тэмцэхийг уриалсан байна. Коминтерний Гүйцэтгэх Хорооны IX бүгд хурлын зөвлөмжүүд, Хятад дахь болон ХКН-ын байдлын тухай шинэ материалууд нь Хятадад хувьсгалын эсрэг аллага хядлага ширүүссэнтэй холбогдон Зөвлөлт Холбоот Улсад хуралдуулахаар шийдсэн намын VI их хурлын баримт бичгүүдийн үндэс нь болсон юм.

ХКН-ын VI их хурал Москва мужийн Наро-Фоминскийн районы Первомайское тосгонд хуралджээ. Их хуралд шийдвэрлэх эрхтэй 84, зөвлөлдөх эрхтэй 34 төлөөлөгч оролцсоны 60 гаруй хувь нь ажилчин ангийн төлөөлөгч байжээ.

Их хурал «Олон улсын байдал ба ХКН-ын зорилтын тухай» Коминтерний төлөөлөгчдийн илтгэл, ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Цюй Цю-бо-гийн тавьсан ХКН-ын Төв Хорооны тайлан илтгэл, цэргийн талаар авсан арга хэмжээний тухай Жоу Эн-лайн хийсэн тайлан илтгэл, түүнчлэн үйлдвэрчний эвлэлүүдийн аж-

* Правда, 1978. 7. 13, № 191,

лын тухай тариачны хөдөлгөөн ба газар тариалангийн шинэтгэлийн тухай сонсчээ. Шинж чанараараа хөрөнгөтний ардчилсан хувьсгал гэж Хятадын хувьсгалыг тэр үеийн шинж байдлаар нь үнэлсэн үнэлэлтэнд төлөөлөгчид их анхаарал тавьж байлаа. Энэ нь тухайн асуудлаар намын дотор зүүнтний ойлголт байснаас бас шалтгаалжээ.

Ажилчны асуудлын талаархи их хурлын баримт бичгүүдэд пролетари нарын дийлэнх олныг өөртөө татах явдлыг ХКН-ын гол зорилт болгон дэвшүүлжээ. Тэгэхдээ жинхэнэ үйлдвэрийн ажилчдын зохион байгуулалттай хөдөлгөөн, «тариачны хөдөлгөөнд пролетари нарын улам нэмэгдэж буй удирдах роль»-д онцгой анхаарахыг зөвлөжээ.

Хятадын коммунистуудын чуулга уулзалт газар тариалан-тариачны асуудалд буурь суурьтай хандаж тосгон дахь нийгэм-эдийн засгийн харьцаанд тодорхой дүгнэлт хийж, тариачны хөдөлгөөнд ХКН-аас баримтлах стратеги тактикийг боловсруулжээ. Их хурлаас газар тариалангийн хувьсгал бол өнөөгийн үе шатны үндсэн агуулга мөн гэж заагаад газрын эздийн бүх газрыг хурааж, газаргүй буюу бага газартай тариачдад хувааж өгөх лоозонг гол зорилт болгон тодорхойлжээ. Харин бүх газрыг улсын болгох лоозонг цагаас нь өмнө дэвшүүлэхийг их хурал буруушааж тэр нь тариачин олон түмний шаардлагад одоохондоо тохирохгүй бөгөөд тухайн асуудлыг ХКН хувьсгал ялсны дараа эргэж харах болно гэж тэмдэглэжээ. Үүнтэй холбогдуулан газрын асуудлаар Мао Цзэдуны баримтлаж байсан хэт довтолгох, ХКН-ыг тариачин олноос хөндийрүүлэхэд хүргэх байр суурийг их хурал дээр хурцаар шүүмжилсэн юм. Мао Цзэ-дун бүр 1921 оны намар «газрын эзэд, тариачдыг ялгалгүй бүх газрыг хураах зорилт дэвшүүлсэн боловч ХКН-ын Төв Хороо түүний саналыг эсэргүүцэж Төв Хороо энэ асуудлаар удирдамж өгч, тийм үзэл бодол буруу болохыг цохон заасан билээ» гэж Цюй Цю-бо тэмдэглэсэн байна.

Их хурлаас ХКН-ын удирдлагын дор тариачдын байгууллага тэмцлийн бүх хэлбэрийг ашиглаж, партизаны хөдөлгөөнийг удирдах явдлыг эрчимжүүлж хөдөө орон нутагт намын зэвсэгт хүчнийг байгуулах, тариачдын заримдаг шаардлагыг газар тариалангийн хувьсгалын гол лоозонтой чадварлагаар хослуулах чигийг яамд өгчээ.

ХКН-ын их хурлын хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд цэргийн асуудал анх удаа оржээ. Жоу Эн-лайн тавьсан илтгэлд энэ талаар намаас явуулж байгаа үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийгээд, хойшид тавих чухал зорилтыг тодорхойлсон байна. Тухайлбал, Мао Цзэдуны цэрэг «Энд тэнд хэсэн тэнүүчилдэг арми болж дээрэм тонуул хийх нь цөөнгүй байгааг» илтгэгч шүүмжилжээ. Зөвлөлийн нэрт жанжнуудын зөвлөмжөөр тусгай комисс гаргаж, улаан арми байгуулж түүний стратеги, тактикийг боловсруулах, кадр дарга нар, улс төрийн ажилтнуудыг сонгон авах, шинээр байгуулж байгаа зэвсэгт хүчний дотор намын удирдах үүргийг хангах тухай зарчмын заалт боловсруулжээ. Эдгээр заалт ач холбогдолтой, бат орших хүч чадалтай нь дараа дараачийн жилүүдэд нотлогдсон юм.

VI их хурал намын байгууллагын зорилтод их анхаарал тавьсан юм. Их хурлаас нам, олон түмэн, юуны өмнө нам, аж үйлдвэрийн гол салбарын үйлдвэрийн газрын ажилчид хоёрын холбоо суларсныг заажээ. «Нам өөрийн бааз суурь болсон ажилчдаа алджээ. Гол салбаруудад намын үүр бараг алга байна. Хэсэг хотуудад намын байгууллага огт байхгүй байна» гэж төлөөлөгчид тэмдэглэсэн байна.

ХКН-ын Төв Хорооны зохион байгуулалтын хэлтсийн мэдээгээр VI их хурал хуралдах үед намын гишүүдийн 10,9 хувь нь ажилчид, 76,6 хувь нь тариачид, 0,8 хувь нь цэрэг 6,9 хувь нь сэхээтэн болон нийгмийн бусад давхрагын хүмүүс байжээ. Их хурлын төлөөлөгчид ийм байдлыг маш

түгшүүртэйд тооцож ХКН нийгмийн бүтэц, үзэл суртал, улс төрийн шинж чанараараа жижиг хөрөнгөтний нам болон хувирч мэдэх аюулын тухай ярьжээ. Иймд их хурал «аж үйлдвэрийн нэн чухал салбаруудын томоохон үйлдвэрийн ажилчдын дунд орж тэнд зохион байгуулалтаа бэхжүүлэхийг ХКН-ын нэн тэргүүний зорилт гэж тодорхойлжээ. Их хурал «цаашид намын эгнээг аж үйлдвэрийн пролетари нараар л өргөжүүлж, пролетарийн элементээр намын үндэс суурь тавихыг» шаарджээ. Орон нутгийн намын байгууллагуудыг тосгоны пролетари нар болон ядуулаг элементүүдээр өргөжүүлэх, намд элсэгчдийг нэгбүрчлэн хэлэлцэх үндсэн дээр тэдгээрийн нийгмийн бүрэлдэхүүнийг хатуу зохицуулах зорилт тавьжээ. Гэвч их хурлын эдгээр шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд ХКН хотоос хөдөө тийш албан хүчээр ухрах болсон объектив болон тухайлбал Мао Цзэдун түүний талынхны пролетарийн эсрэг мөрийн хөтөлбөр субъектив маягийн шалтгааны улмаас ноцтой саад учирч байсныг тэмдэглэвэл зохино.

ХКН-ын VI их хурал намын ажилд оршиж байгаа гол дутагдал нь намын аппаратыг хүнд суртлын байгууллага болгох, хамтран шийдвэрлэх зарчмыг гажуудуулах, үйл ажиллагааны ардчилсан хэлбэрүүд хөгжөөгүй, түүнчлэн бүлэглэх, өөрөөр сэтгэгчидтэй зарчимгүй авирлах буюу бүр залхаан цээрлүүлдэг явдал болохыг нэрлэн заажээ. Их хурал намын зохион байгуулалтын бүх ажлыг үндсээр нь өөрчилсний үндсэн дээр дээрх эрүүл бус үзэгдлүүдийг эрс шийдвэртэй даван туулахыг шаарджээ.

Намын программын төсөл боловсруулж, түүнийг VI их хуралд оруулж хэлэлцүүлэхийг их хурал шинэ Төв Хороонд даалгажээ. Гэтэл 1935 оноос хойш намын удирдлагыг гартаа авсан Мао Цзэдун их хурлын энэ тогтоолыг хөсөрдүүлсэн байна.

VI их хурлаар Хятадын Коммунист намын шинэ дүрмийн төслийг хэлэлцсэн байна. Удирдлагын хамтын зарчмыг хангаж, намын дотоод ардчилалыг хөгжүүлэх зорилгоор ХКН-ын их хурал зарлан хуралдуулах тухай жил бүр хэлэлцдэг байжээ. Гэвч VII их хурал хэд хэдэн удаа хойшлогдож, бараг 17 жил өнгөрсөн хойно буюу 1945 онд Мао Цзедуны шийдвэрээр олон интернационалч коммунистыг намын удирдлагаас зайлуулж, тэднийг харгислан, Хятадын Коммунист Намд Мао Цзедуны «хятадчилсан марксизмыг» тулган хүлээлгэсний дараа болсон юм.

Маогийн талыг баримтлагч түүхчид ХКН-ын VI их хурлын шийдвэрийн ач холбогдлыг аль болохоор бууруулахыг оролдож байна. Тэд их хурлын ажиллагааны сул талыг товойлгож гол заалтуудыг (тухайлбал, газар тариалан-тариачны асуудал, партизаны хөдөлгөөний тухай, тосгонд тулгуур бааз ба зэвсэгт хүчийг бий болгох зэрэг олон зүйл) эс дурдах, эсхүл тэдгээрийг ичгүүр сонжуургагүйгээр Мао Цзэ-дуны санаачлага болгож байна. Иймд Хятадын намын түүхийн ном зохиолоос ХКН-ын VI их хуралд оролцогчдын зүгээс Мао Цзэ-дуныг шүүмжилсэн тухай олж үзье гэвэл талаар болох нь мэдээж. Бүр 50 жилийн өмнө энэ их хурлын нэг төлөөлөгч Маогийн адал балмад үзэл санааг маоцзедунизм гэж нэрлэж байсныг тэмдэглүүштэй.

Хятадын Коммунист Намын бүх түүх, түүний дотор ХКН-ын VI их хурлын материал ч гэсэн маоизм бол марксизм-ленинизмд гүнээ харш, дайсагнасан урсгал байсан ба байсаар буйг батлан харуулж байна.

Орчуулсан **Д. Начин**